



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 111

Бөхт

┌ Ашигт малтмалын хайгуулын тусгай ┐
зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар талбай
олгохоос татгалзах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Өндөршил сумын нутагт сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн 1911,66 га талбай нь Их нартын байгалийн нөөц газрын бүсэд оршдог, Хар дэл, Хуурай хонхорын цагаан толгой, Гэр чулуу зэрэг өвөлжөөний газартай давхцаж байгаа тул хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн 77.7 хувийн саналаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар талбай олгохоос татгалзсугай

2.Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан талбайн хэмжээ, солбицолыг хавсралтаар баталсугай.

3.Тогтоолыг Аймгийн Засаг даргад хүргүүлэхийг сумын Засаг дарга (У.Алтанхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.МӨНХЦЭЦЭГ

482301061